



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№220 /429/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.12.07

Цаг үе, үйл явдал

УМАРД АТЛАНТЫН ГЭРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН ТӨВҮҮДИЙН ТҮНШЛЭЛИЙН ХОЛБООНЫ ГИШҮҮН ОРНУУДЫН НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГТ ОРОЛЦЛОО



НАТО-гийн Боловсрол, сургалтын түншлэлийн төвүүдийн үйл ажиллагааг сурталчлах Нээлттэй хаалганы өдөрлөг өнгөрсөн сарын 13-16-ны өдрүүдэд Бельги улсын Брюссель хотод байрладаг НАТО-гийн төв байранд амжилттай болж өндөрлөлөө.

Умард Атлантын гэрээний байгууллагын боловсрол сургалтын төвүүдийн түншлэлийн холбоонд нийт 34 байгууллага хамрагддагаас энэхүү Нээлттэй хаалганы өдөрлөгт 27 төв хүрэлцэн ирж, өөрсдийн үйл ажиллагаа, бодлого зорилгоо сурталчлахын зэрэгцээ харилцан туршлага солилцов. Уг өдөрлөгт Монгол Улсаас

Бельги Улсад суугаа Элчин сайдын яамны атташе хурандаа М.Батчулуун болон Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн захирагчийн орлогч, энхийг дэмжих ажиллагааны сургалтын төвийн дарга дэд хурандаа Н.Гантулга нар оролцсон юм.

НАТО-гийн Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Мирча Геоанагин нээлтийн арга хэмжээний үеэр хэлсэн үгэндээ "Бид бүхний бүтээн байгуулсан эвслийн төлөө гайхалтай ажилласанд талархал илэрхийлж, сургалтын төвүүдийг боловсрол, сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан аюулгүй байдлын гол үүрэг гүйцэтгэгч" хэмээн онцлон тэмдэглэв. Мөн тэрээр НАТО нь аюулгүй, амар

амгалан дэлхий болон Атлантыг дамнасан дэлхийн аюулгүй байдлын тулгуур хэвээр байна. Энэ бол бид бүхний эрхэм зорилго хэмээсэн юм.

Манай улсын Зэвсэгт хүчний Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төв нь уг холбоонд 2014 онд гишүүнээр элсэн орж, хамтын ажиллагааг өргөжүүлэн НАТО-гийн сургалтын стандартын дагуу цэргийн багуудын ажиллагааны өмнөх бэлтгэл сургалтыг зохион байгуулах, харилцан багш солилцох, сургагч багш нарыг бэлтгэх ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-13	-28

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.443	3.446
EUR	3.620	3.650
CNY	489	492
RUB	52.20	53.50
JPY	25	25.70
KRW	2.60	2.64

ЗУРХАЙ



2022.12.07 / ЛХАГВА ГАРАГ /
БИЛГИЙН ТООЛЛЫН 145

**ӨВЛИЙН ТЭРГҮҮН ЦАГААГЧИН
ГАХАЙ САР
ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ
ХӨХ МОРЬ ӨДӨР**

Үс засуулбал:

Өлзийтэй сайн

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.27-17.00

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Хуран үйлдэхүй

“ХАНДЛАГАА ӨӨРЧИЛЬЕ, ХАРИУЦЛАГАА ДЭЭШЛҮҮЛЬЕ” СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Батлан хамгаалах яамны бодлого, үйл ажиллагааг сурталчлах, бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, ёс суртахуун, харилцаа хандлага, төлөвшилд дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, соён гэгээрүүлэх, зорилгоор Хүндэт харуулын тусгай рот, Харуул үйлчилгээний тусгай рот, Цэргийн цагдаагийн ротын офицер, ахлагч нар, хугацаат цэргийн алба хаагчидтай цуврал сургалтуудыг зохион байгуулж байна.

Энэ удаа Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн Ажлын албаны мэргэжилтэн, Батлан хамгаалахын сайдын дэргэдэх иргэний зөвлөлийн нарийн бичгийн дарга хошууч А.Октябрь "Батлан хамгаалах яамнаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Иргэний зөвлөлөөс хэрэгжүүлж буй ажил, үр дүн", ҮБХИС-ийн АБДС-ийн Нийгэм хүмүүнлэгийн тэнхимийн дарга доктор, дэд



профессор, иргэний зөвлөлийн гишүүн И.Чинбат "Эх оронч үзэл" сэдвээр тус бүр хоёр цагийн сургалтыг зохион байгуулан, санал сэтгэгдлийг нь сонслоо.

Сургалтын төгсгөлд хошууч А.Октябрь "Зөв харилцаа-Зөв хандлага" сэдэвт богино хэмжээний дүрс бичлэгийг үзүүлж ХХТР, ХҮТР, ЦЦР-ын офицер, ахлагч болон хугацаат цэргийн алба хаагчдад хандан хандлагаа өөрчилж, хариуцлагаа дээшлүүлэн ажиллахыг уриалсан юм.

Ахмад Т.ДЭЛГЭРМАА



“ЦОЛ БҮХЭН САЙХАН” УРАЛДААНД ТҮРҮҮЧ НАР ТЭРГҮҮЛЛЭЭ

Хошууч генерал Ч.Самбуугийн нэрэмжит Алтангадас одонт Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн алба хаагчдын дунд "Цол бүхэн сайхан" сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдлаа.

Тэмцээнд цол бүхнийг төлөөлсөн 14 баг тамирчид оролцож хурд хүчээ сорьсноос

эрэгтэйчүүдийн төрөлд тэргүүн байрт "Түрүүч" баг, дэд байрт "Ахмад"-ын хоёрдугаар баг, эмэгтэйчүүдийн төрөлд "Ахлагч" баг тэргүүн байрт, дэд байрт ажилтан албан хаагчдын баг тамирчид тус тус эзэллээ.

Шагналыг ангийн захирагч, дэд хурандаа Г.Дүнжингарав гардуулан өгч, баяр хүргэлээ.

Хошууч Б.АЛТАНШАГАЙ

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 650,941,156

Эдгэрсэн

Нийт: 627,648,612

Нас барсан

Нийт: 6,649,897

Цаг үе, үйл явдал

ЭМЭГТЭЙ АЛБА ХААГЧДЫН “БИДНИЙ ХОББИ” ҮЗЭСГЭЛЭН ДЭЛГЭГДЭВ



Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн эмэгтэйчүүдийн зөвлөл 2022 оны үйл ажиллагаагаа дүгнэж, 2023 оны зорилго зорилтоо тодорхойлсон зөвлөгөөнийг зохион байгууллаа.

Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга, хошууч Б.Цолмонцэцэг зөвлөлийн журмыг танилцуулж, өөрчлөлтийг өөрөөсөө эхэлж, эмэгтэйчүүд манлайлагч байхын төлөө өөрсдөө хичээл зүтгэл гаргахыг уриалаад бүсгүйчүүдийн манлайлал эрчүүдийнхээс илүү бартаатай байдгийг ч тодотгов.

Зөвлөгөөнөөр эмэгтэй алба хаагчдын анги хамт олондоо хийж хэрэгжүүлэх бүтээлч ажил, хугацаат

цэргийн алба хаагчид руу чиглэсэн арга хэмжээ зэргээ онцолж, 2023 онд илүү өргөн хүрээнд зохион байгуулахаар ярилцлаа.

Зөвлөгөөний төгсгөлд эмэгтэй алба хаагчдын “Бидний хобби” үзэсгэлэн дэлгэгдэж, хугацаат цэргийн алба хаагчдын “Бид эх орны хөвгүүд” урлагийн тоглолтыг ангийн бие бүрэлдэхүүнд толилуулсан юм. Энэ үеэр “Уран бичигтэн” уралдааны тэргүүлэгчдийн шагналыг ангийн захирагч, хурандаа Ц.Төрмөнх гардуулан өгөв.

Хошууч О.Отгонцэцэг

Дэлхийд

ДЭЛХИЙН 8 ТЭРБУМ ДАХЬ ИРГЭН БОЛЖ АВСТРАЛИД МЭНДЭЛСЭН А.МЭРГЭН ХҮҮД ТӨРСНИЙ ГЭРЧИЛГЭЭ ОЛГОЖЭЭ



Дэлхийн хүн ам 8 тэрбум болсон 2022 оны арваннэгдүгээр сарын 15-ны өдөр Австрали улсын Канберра хотод Монгол Улсын иргэн Б.Ананд, Э.Лхагвасүрэн нарын гэр бүлд хүү мэндэлсэн хүү 8 тэрбум дахь иргэн болсныг хэвлэлүүд мэдээлсэн билээ. Залуу гэр бүл хүүдээ А.Мэргэн хэмээх нэр хайрлажээ.

Дэлхийн найман тэрбум дахь иргэн А.Мэргэн хүү аав, ээж, эмээгийн хамт Австрали улс дахь Монголын Элчин сайдын яаманд очиж Элчин сайд Д.Даваасүрэнгээс төрсний гэрчилгээгээ авсан байна.

Цахим шууданд

ДАЙЧИН АЛДРЫН “СОЁМБО” ТАНХИМТАЙ БОЛОВ



Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас Ховд аймаг дахь Хөгжил политехник коллежтой хамтран хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх, батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, тус аймгаас төрөн гарсан Монгол Улсын баатрууд, генералуудыг алдаршуулах, тэдний үйл хэргийг залуус, хойч үеийнхэнд сурталчлан таниулах зорилгоор тус коллеж дээр “Монгол цэрэг-Дэлхийн цэрэг” дайчин алдрын “Соёмбо” танхимыг тохижуулан хүлээлгэн өглөө.

Уг танхимын нээлтийн ёслолын ажиллагаанд Ховд аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Б.Ганхуяг, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Даваадорж, Ховд аймаг дахь Хөгжил политехник коллежийн захирал

доктор Д.Баярмаа, Жаргалант сумын Засаг дарга Ц.Цогтбаяр нар болон Цэргийн штабын офицерууд, тус сургуулийн багш, сурагчид оролцлоо.

Энэхүү ёслолын ажиллагааг нээж Цэргийн штабын дарга хурандаа Б.Ганхуяг хэлсэн үгэндээ “Хүүхэд, залуучууд маань энэхүү танхимтай танилцсанаар Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний түүх, дайчин замнал, өнөөгийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй ойлголттой болно. Мөн өнгөрсөн хугацаанд тус аймгаас төрөн гарсан Монгол Улсын баатрууд, генералуудын үйл хэрэг, байгуулсан гавьяаг сайтар судлахын хамт аймаг, орон нутгийн түүхэн мэдээллийг судлан мэдэх боломж бүрдэж байгаа”-г онцлолоо хэмээн бидэнд мэдээлэв.

Хурандаа Б.ОТГОНБАЯР



БЯЦХАН ЗҮРХ БҮХЭНД ХАЙР ДҮҮРЭН МЯЛААЛГА ӨРГӨЛӨӨ



Батлан хамгаалах салбар нийгмийн хариуцлагын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгын дор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр”-т зориулсан өдөрлөгийг зохион байгууллаа.

Тус өдөрлөгт хүрэлцэн ирсэн хүүхэд багачууд, тэдний ар гэрийнхэнд зориулан ЦДБЭЧ-ын уран бүтээлчид, “Тэмүжин өрлөг” сургуулийн авьяаслаг сурагчид, хүрэлцэн ирсэн зочид хамтран хүндэтгэлийн тоглолтыг зохион байгуулж уран бүтээлүүдийн дээжсээ өргөн барилаа.

Энэхүү арга хэмжээнд оролцсон хүүхэд багачууд цэргийн чуулгын ах эгч нарынхаа уран бүтээлийг шимтэн сонсож, хамтдаа дуулан жаргаж, нэгэн өдрийг хөг эгшиг, аз жаргалаар дүүрэн цалгиж өнгөрүүлсэн юм.

Хүүхэд бүхэн эрүүл энх өсөн торниж, эрх тэгш аз жаргалаар дүүрэн цалгих гэгээн бүхнийг ерөөж энэхүү өдөрлөгт нэгдэн уран бүтээлийн мялаалга өргөсөндөө ЦДБЭЧ-ын хамт олон талархалтай байна.


Сургалт

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №32

3 НГ ДЭВСГЭРИЙГ ЗӨВ, ЦЭВЭР БИЧИХ

Их инхлэг бол монгол бичгийн цагаан толгойн өвөрмөц дэвсгэр үсэг юм. Монгол хэлээр, хэлний хойгуур хэлдэг “Н” авиаг монгол бичигт тусгайлан тэмдэглэж, хэлний урдуур хэлдэг “Н”-ээс ялгаж өгсөн байдаг. Их инхлэг бол “Зөөлөн дэвсгэр” үсгийн нэг болно. Монгол хэлнээ, НГ үсэг үгийн эхэнд ордоггүй, мөн үе үсэг болж задардаггүй. Зөвхөн үгийн дунд, адагт дэвсгэрлэж ордог онцлогтой.

Дармал, бичмэл тигээр:



НГ үсэг үгийн дунд, хоёр үеийн заагт тохиолддог. Үүнийг ОЦМХ-ний кирилл бичлэгээр тайлбарлавал: эхний үе нь Н, Г, М гийгүүлэгчийн аль нэгээр төгссөн байх ёстой. Хоёрдугаар үе нь Х, Г, Н болон заримдаа С, Б-гээр эхэлсэн үгийг монгол бичгээр бичихэд эхний үеийг төгсгөж буй гийгүүлэгч нь их

инхлэг дэвсгэр /НГ/ байдаг гэж мэдэж болно. Жбэл: ...н+х... /манхан, хонх, энх/, ... н+г... /хонгор, энгэр, хөнгөн/, ...н+с... /тансаг, тонших, дүнсгэр/, ...г+н... /магнай, эгнээ, сөгнөх/, ...м+б/м/... /соёмбо, домбо, хамба /торго/, цэмбэ./ гэх мэт.